



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/272

Сүхбаатар сум

Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн төсөл сонгон шалгаруулах, үйлдвэрлэлд зөвшөөрөл олгох, сунгах, түтгэлзүүлэхэд хяналт тавих ажлын хэсгийг тэмцэх тухай

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4.7, 14.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.3, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.7, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А-84 дугаартай тушаалаар батлагдсан "Согтууруулах ундааны үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, үйлдвэрлэлд хяналт тавих журам"-ын 4.3, 4.4, 4.5, 4.6 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундааны үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түтгэлзүүлэхэд хяналт шалгалт хийх, хэрэгжилтийг хангуулах, санал дүгнэлт гаргах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Ёндонжамц

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Б.Мөнхтөр

-Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын
дарга

Гишүүд:

С.Чинбат

-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын
Хүнсний чанар, стандартын хяналтын
улсын байцаагч

С.Мөнхдаваа

-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын
Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын
улсын байцаагч

У.Энхбат

-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын
Эрүүл ахуй, халдвар хамгааллын
хяналтын улсын байцаагч

Ч.Алтангэрэл

-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын
Хэмжилзүйн хяналтын улсын байцаагч


Н.Даваадорж

-Мандал сумын Татварын тасгийн
Татварын улсын ахлах байцаагч

Б.Энхмандах	-Мандал дахь сум дундын цагдаагийн хэлтсийн Нийтийн хэв журам, хамгаалах хэсгийн дарга
Р.Энхтуул	-Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнс, нийтийн хоол, худалдааны асуудал хариуцсан мэргэжилтэн
Ч.Батболд	-Мандал дахь Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч
Л.Анхцэцэг	-Аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн баталгаажуулалтын ахлах шинжээч
Д.Уранчимэг	-Аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн дарга

2.Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох журам, стандартыг үндэслэн хяналт шалгалтыг ажлыг зохион байгуулж, санал дүгнэлтийг гарган Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлэн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Д.Ёндонжамц/, нарийн бичгийн дарга Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Мөнхтөр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ОРГИЛ